

ӨМНӨХ ҮГ

“Иргэн баян бол улс баян” хэмээх үг буй. Үүний цаана иргэн бүр эрх үүргээ ухамсарлан, өөрийн амьдрал ахуйдаа эзэн болж чадвал улс орны хөгжил сайн сайхан байхыг өгүүлж буй хэрэг билээ. Нөгөө талаас, аливаа улсын хөгжлийн эрхэм зорилго бол ард иргэдийнхээ сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх явдал байдаг. Энэ зорилгод хүрэхэд улс орон эдийн засгийн хувьд чадамжтай, хувь хүмүүс санхүүгийн хувьд чадамжтай байх нь илүү чухаг. Төр засаг дангаараа ажиллаад энэ зорилгыг биелүүлэх боломжгүй, гагцхүү үүнд иргэн бүрийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачлага, оролцоо хэрэгтэй юм.

Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2015 онд батлуулаад байна. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд хувь хүн Та өөрийн санхүүгээ зөв удирдан жолоодох, тухайлбал,

хувь хүний санхүүгийн талаарх үндсэн ойлголт, тодорхойлолтууд, орлого, зарлагаа тооцоолох, хянах, хуримтлал, хадгаламжтай болох, хөрөнгө мөнгөө зарцуулахтай холбогдон гарч болох аливаа эрсдэлт байдлаас сэргийлэх, хамгаалах, эдийн засаг, санхүүтэй холбоотой зөв, оновчтой шийдвэр гаргах зэрэг өөрийн өдөр тутмын болоод ирээдүйн эдийн засгийн амьдралд нэн шаардлагатай, мэдвэл зохих хувь хүний санхүүгийн мэдлэг, ур чадварыг эзэмших юм.

Бид хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахыг тэмүүлдэг. Тэгвэл хэрэгцээгээ бүрэн хангахын тулд хязгаарлагдмал нөөц, хөрөнгө мөнгийг зөв зарцуулахтай холбоотой хувь хүний санхүүгийн төлөвлөлт танд маш чухал. Хувь хүн та өөрийн бүхий л талын нөөц боллоцоог ашиглах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах, мэдээлэлдээ тулгуурлан шийдвэр гаргах, сонголт хийхдээ хэрэглэх зөв мэдлэг, хандлага, ур чадвар, зан үйл, дадал зуршлыг энэ сурах бичгээс олж авна гэдэгт бид найдаж байна.

МОНГОЛБАНК
ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

1.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИЛГО, ТӨРӨЛ

www.sankhuuginbolovsrol.mn

Хөрөнгө бол хувь хүн болон аж ахуйн нэгжийн өмчлөлд буй мөнгөөр хэмжигдэх боломжтой санхүүгийн нөөц юм. **Хөрөнгө оруулалт** бол ирээдүйд ашиг олох зорилгоор мөнгө эсвэл цаг хугацаа, эсвэл нөөц баялагийг ашиглах үйл явц юм.¹ Маш энгийнээр тодорхойлбол, мөнгөө өсгөж арвижуулах зорилгоор өнөөдөр худалдан авч болох зүйлсийг хөрөнгө оруулалт гэж ойлгож болно.

Хөрөнгө оруулалтын зорилго нь мөнгөө өсгөх буюу ашиг олоход оршдог. Өөрөөр хэлбэл, мөнгөөр мөнгө олох, мөнгийг арвижуулахад хөрөнгө оруулалт чиглэгдэнэ. Ямар ч хөрөнгө оруулалтын зорилго тодорхой, хэмжиж болохуйц, санхүүгийн тодорхой хэрэгцээг хангахуйц бөгөөд цаг хугацаатай байх ёстой. Санхүүгийн зорилгыг богино, дунд, урт хугацааны гэж ангилдаг шиг хөрөнгө оруулалтын зорилго ч мөн адил ангилагдана.

Хөрөнгө оруулалтаас ирээдүйд олж болох ашгийг хөрөнгө оруулалтын өгөөж гэж нэрлэдэг бөгөөд энэ нь хувьцааны хувьд ногдол ашиг, бондын хувьд хүү, үл хөдлөх хөрөнгийн хувьд түрээсийн орлого гэх зэргээр илэрдэг.

Хөрөнгө оруулалтын хэрэгсэл гэдэг нь хөрөнгө оруулагчийн зүгээс хөрөнгө оруулж болох санхүүгийн болон таваарын захын бүтээгдэхүүн юм.

Хөрөнгө оруулалтыг биет болон биет бус, уламжлалт болон уламжлалт бус, эрсдэл ихтэй болон эрсдэл багатай гэх зэргээр янз бүрийн шинжээр ангилдаг. Ханшийн өсөлт, ногдол ашиг, хүүний орлого гэх зэрэг мөнгийг өсгөж болох хамгийн сайн мэдэх хөрөнгөд (тухайлбал, бэлэн мөнгө, үл хөдлөх хөрөнгө, бонд, хувьцаа гэх мэт) хийх хөрөнгө оруулалтыг уламжлалт хөрөнгө оруулалт гэх бол хувьцаа, бонд болон бэлэн мөнгөнөөс бусад төрлийн хөрөнгөд хийх хөрөнгө оруулалтыг уламжлалт бус хөрөнгө оруулалт гэнэ.

¹ <https://en.wikipedia.org/wiki/Investment>

Уламжлалт хөрөнгө оруулалттай харьцуулахад уламжлалт бус хөрөнгө оруулалт нь дараах шинж чанартай. Үүнд:

- Хувьцаа, бонд зэрэг уламжлалт хөрөнгө оруулалтаас хамаарах хамаарал багатай байна.
- Энэ төрлийн хөрөнгө оруулалтын зах зээл дэх өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэцүү
- Хөрвөх чадвар харьцангуй муутай байдаг.
- Худалдан авах, худалдах арилжааны зардал харьцангуй ихтэй байдаг.
- Эрсдэл болон өгөөжийг тооцоход хүндрэлтэй байдаг.
- Хөрөнгө оруулахаасаа өмнө нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай.

Хөрөнгө оруулалтын олон сонголтуудын нэг талд хамгийн аюулгүй, найдвартай хөрөнгө оруулалт болох Засгийн газрын бонд, хадгаламжийн сертификат, хадгаламжийн данс, нэр хүнд бүхий компанийн бонд, хувьцаа зэрэг багтах бол нөгөө талд, харьцангуй богино хугацаанд их хэмжээний ашиг олох сонирхлыг төрүүлдэг, эрсдэл ихтэй хөрөнгө оруулалтууд багтдаг. Эрсдэл ихтэй хөрөнгө оруулалт их хэмжээний ашиг амладаг ч амжилт олох нь бага бөгөөд хөрөнгө оруулагч хөрөнгийнхөө ихэнх хэсгийг, тэр ч байтугай бүгдийг алдаж болох магадлалтай. Эрсдэл өндөртэй хувьцаа, бонд, зарим төрлийн үл хөдлөх хөрөнгүүд, үнэт чулуу, үнэт металл, цуглуулга, бараа таваар, опцион зэрэг нь хөрөнгө оруулалтын энэ төрөлд хамаардаг.

Хүснэгт 1.1. Хөрөнгө оруулалтын эрсдэл ба хөрөнгө оруулагчдын хэв шинж

Эрсдэл багатай хөрөнгө оруулалт	Эрсдэл ихтэй хөрөнгө оруулалт
Санхүүгийн боломжгүй, хөрөнгө оруулалтын суурь мэдлэггүй хүмүүс	Санхүүгийн боломжтой, хөрөнгө оруулалтын өндөр мэдлэгтэй хүмүүс
Ахимаг настай хөрөнгө оруулагчид	Залуу, идэр насны хөрөнгө оруулагчид
Орлого багатай, эрсдэл даах чадваргүй хөрөнгө оруулагчид	Орлого ихтэй, эрсдэл даах чадвартай хөрөнгө оруулагчид
Хүүхэдтэй гэр бүл, өрх айл /Өрхийн хариуцлага хүлээдэг/	Хүүхэдгүй гэр бүл, эсвэл ганц бие хүмүүс /Өрхийн хариуцлага хүлээдэггүй/

Хэдийгээр хүн бүрт хөрөнгө оруулалт хийх тодорхой зорилго байдаг ч сонголт хийхээсээ өмнө хөрөнгө оруулалтад нөлөөлж болох хүчин зүйлсийн талаар мэддэг байх хэрэгтэй. Энэ нь хөрөнгө оруулалтын найдвартай байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, орлого ашгаа өсгөх, хөрөнгө оруулалтын хөрвөх чадварыг сайжруулах зэрэг ач холбогдолтой.

Хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг үндсэн дөрвөн төрөлд хувааж болно. Үүнд:

1. Орлогын хүчин зүйл. Хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтууд тогтвортой орлогын эх үүсвэрт тооцогддог. Учир нь хэзээ, хэдий хэмжээний орлого олохоо урьдчилан мэдэх боломжтой байдаг.

2. Өсөлтийн хүчин зүйл. Хөрөнгө оруулж байх үеийн үнээс хөрөнгө оруулалтын үр ашиг хүртэх үеийн үнэ өсөх үед энэ үр дүн бий болдог. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт гэсэн үг.

3. Хөрвөх чадварын хүчин зүйл.

Хөрвөх чадвар бол ямар нэг эд зүйл эсвэл бараа таваар үнэ цэнээ алдахгүйгээр мөнгөнд шилжих чадвар юм. Маш богино хугацаанд бэлэн мөнгө болж хувирах боломжтой чекийн болон хадгаламжийн дансууд нь хамгийн хөрвөх чадвар сайтай. Зарим хөрөнгө оруулалтууд тухайлбал, үл хөдлөх хөрөнгийг яаралтай худалдахын тулд хямд үнийг санал болгох хэрэгтэй болох учир хөрвөх чадвар муутай байдаг.

4. Эрсдэлийн хүчин зүйл. Хөрөнгө оруулалтад инфляцийн, хүүний, зах зээлийн, валютын ханшийн, үйл ажиллагааны гэх зэрэг олон эрсдэлүүд нөлөөлдөг.

Хөрөнгө оруулалтын хэлбэрээс хамаарч эрсдэл, өгөөж, хөрвөх чадварын хэмжээ харилцан адилгүй байна.

2 Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes. (2012), "Personal Finance", 10th ed. P431.

Хүснэгт 1.2. Хөрөнгө оруулалтын хэлбэр /өгөөж, эрсдэл, хөрвөх чадвар/

	Хөрөнгө оруулалтын хэлбэрүүд	Аюулгүй байдал	Эрсдэл	Ашиг/Өгөөж	Өсөлт	Хөрвөх чадвар
Уламжлалт ХО	Энгийн хувьцаа	Дунд	Дунд	Дунд	Их	Дунд
	Давуу эрхтэй хувьцаа	Дунд	Дунд	Их	Дунд	Дунд
	Компанийн бонд	Дунд	Дунд	Их	Бага	Дунд
	Засгийн газрын бонд	Өндөр	Бага	Бага	Бага	Сайн
	Хамтын сан	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд
	Үл хөдлөх хөрөнгө	Дунд	Дунд	Дунд	Дунд	Муу
Уламжлалт бус ХО	Опцион	Бага	Их	тодорхойгүй	Бага	Дунд
	Таваар	Бага	Их	тодорхойгүй	Бага	Дунд
	Деривативууд	Бага	Их	тодорхойгүй	Бага	Дунд
	Үнэт металл, үнэт эдлэл	Бага	Их	тодорхойгүй	Бага	Муу

Хүснэгтээс харахад уламжлалт хөрөнгө оруулалтын эрсдэл харьцангуй бага байх бол уламжлалт бус хөрөнгө оруулалт нь эрсдэл ихтэй байна. Эрсдэлийн хэмжээнээс хамаарч өгөөжийн хэмжээ тодорхойлогдож байна.

Хөрөнгө оруулалтыг эрсдэлийн хэмжээгээр нь дараах 4 түвшинд ангилж болно.

3 Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes. (2012), "Personal Finance", 10th ed. P443.

Зураг 1.1. Хөрөнгө оруулалтын пирамид: Эрсдэлийн 4 түвшин



Эрсдэлийг бууруулах зорилгоор янз бүрийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх боломжтой бөгөөд энэ нь “Бүх өндгөө нэг сагсанд бүү хий” гэсэн зарчмын дагуу диверсификаци (тараан

байршуулалт) хийж байна гэсэн үг. Диверсификаци хийснээр нэг хөрөнгө оруулалтаас хүлээх алдагдлыг бусад хөрөнгө оруулалтаас олох ашгаар нөхөж алдагдлаа бууруулж болно.

1.2. ХУВЬЦААНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Та үнэт цаас худалдан авч хөрөнгө оруулалт хийснээр компанийн тодорхой хувийн өмчлөгч болж ногдол ашиг хүртэх, ханшийн зөрүүгээс ашиг олох болон хүүгийн орлого олж мөнгө хөрөнгөө өсгөх боломжтой юм.

Хувьцаа нь бусад хөрөнгө оруулалтын хэрэгслээс илүү их боломжит ашгийг санал болгодог ч, илүү их эрсдэлтэй байдаг. Та нэг хэсэг эсвэл бүх мөнгөө ч алдаж болно. Гэхдээ судалгаа, шинжилгээний үр дүнд хувьцааны хөрөнгө оруулалттай холбоотой эрсдлийг бууруулж болно. Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийх үедээ хоёр асуудалтай тулгарч байдаг. Нэгдүгээрт, хөрөнгө оруулалтын талаарх үнэн зөв мэдээлэл. Хоёрдугаарт, мэдээлэл олдлоо ч түүнийгээ ойлгохгүй бол үнэлгээгээ зөв, сайн хийж чаддаггүй.⁴

ТАНЫ ТАНИН МЭДЭХҮЙД

Хөгжилтэй орнуудын хүн амын 45-80 % нь хувьцааны талаар мэдлэгтэй. Харин манай улсын хувьд хүн амын 12 орчим % нь л хувьцааны талаар ойлголттой байна

Энгийн хувьцаа

Зах зээл дээр нийтэд санал болгож байгаа, саналын эрхтэй хувьцааг энгийн хувьцаа гэнэ. Хувьцаа бол компанийн дүрмийн сан буюу өөрийн хөрөнгийг бүрдүүлдэг санхүүгийн хэрэгсэл юм. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бусдад худалдах боломжтой байдаг. Хувьцааг худалдах үнэ нь худалдан авагчийн хувьцаанд төлөхөд бэлэн байгаа үнээр тодорхойлогддог. Компанийн ирээдүйн борлуулалтын орлого, ашиг, өргөжилт, эсвэл нэгдэлт, бусад хүчин зүйлс нь хувьцааны үнийг өсгөх эсвэл бууруулах шалтгаан болно.

⁴ Стандарт Инвестмент ХХК, (2011) Хувьцааны цагаан толгой, Улаанбаатар, Монгол Улс, 11-р нүүр.

Ногдол ашгийг компанийн цэвэр ашгаас төлдөг бөгөөд компанийн төлөөлөн удирдах зөвлөл(ТУЗ)-өөс хуваарилах ногдол ашгийн хэмжээг баталдаг. Ногдол ашиг бол хувьцаа эзэмшигчдийн хувьд оруулсан хөрөнгө оруулалтаасаа хүртэж буй өгөөж юм.

Саналын эрх ба компанийн үйл ажиллагаанд тавих хяналт

Хувьцаа эзэмшигч болсноор та дараах эрхийг эдэлнэ.

- Бид өөрсдөө авто үйлдвэрийг худалдан авч чадахгүй ч Форд юмуу Тоёота компанийн хувьцааг худалдан авах боломжтой бөгөөд автомашины үйлдвэрлэлээс

бий болох ашгаас ногдол ашиг хэлбэрээр хувь хүртэх боломжтой.

- Компанийн бодлогыг тодорхойлоход оролцож чадна.
- Компанийн ТУЗ-ийг сонгох эрхтэй.
- Ханшийн зөрүүнээс ашиг хүртэнэ.

Хөрөнгө оруулагч дараах шалтгааны улмаас энгийн хувьцаа худалдан авдаг.

Үүнд:

- Ногдол ашиг хэлбэрээр орлого олох;
- Хувьцаа жижигрүүлэлтээр үнийг өсгөх (гэхдээ баталгаа байхгүй);
- Хөрөнгөө өсгөх;
- Татварын хөнгөлөлт эдлэх зэрэг орно.

ТАНЫ МЭДЛЭГТ

“Сүү” ХК-ийн хувьцаа гэхэд л 2008 оны 11-р сарын 27-ны өдөр 1000 төгрөгийн үнэтэй байсан бол 2016 оны 06-р сарын 10-ны өдөр 145000 төгрөгөөр үнэлэгдэж өнгөрсөн 8 жилийн хугацаанд 145 дахин өссөн байна. Уг хувьцааны жил тутмын өгөөж нь ойролцоогоор 86 орчим хувь байсан байна. Энэ нь банкны хадгаламжийн хүүнээс даруй 5-6 дахин их байгаа юм. “Сүү” ХК 2008 оноос үйлдвэрийн шинэ шугам ашиглалтад оруулж хүчин чадал, бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмсэнээр хувьцааных нь ханш ийнхүү өссөн байна. Хувьцаагаар хэрхэн мөнгө хийж болохыг энэхүү жишээ харуулж байна. Гэхдээ хувьцаатай болмогц мөнгө асгарах юм шиг ойлгож болохгүй. Ашиг их бол эрсдэл их гэдгийг хэзээ ч мартаж болохгүй.

Давуу эрхийн хувьцаа

Та энгийн хувьцаа худалдан авахын оронд давуу эрхийн хувьцаа худалдан авч болно. Давуу эрхийн хувьцаа бол энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос өмнө ногдол ашиг хүртэх эрхийг эзэмшигчдээ олгодог хувьцааны нэг төрөл юм. Энэ нь хөрөнгө оруулагчдын давуу эрхийн хувьцааг сонирхдог нэг чухал зүйл.

Давуу эрхийн хувьцаа нь энгийн хувьцаа (хувьцаа эзэмшигчийн хувьд өмчлөгч) болон компанийн бонд (бонд эзэмшигчийн хувьд зээлдүүлэгч)-ын хоорондох хөрөнгө оруулалтыг төлөөлдөг учраас "холимог шинжтэй хөрөнгө оруулалт" гэж нэрлэдэг⁵. Компанийн бондтой харьцуулахад давуу эрхийн хувьцааны өгөөж бондын өгөөжөөс ихэвчлэн бага байдаг бол энгийн хувьцаатай харьцуулахад илүү найдвартай хөрөнгө оруулалт болдог. Учир нь энгийн хувьцааны хөрөнгө оруулалтаас илүү орлого санал болгодог. Мөн ногдол ашгийн орлогод татварын хөнгөлөлт эдлэх боломжтой учраас компаниуд давуу эрхийн хувьцаа худалдан авдаг байна.

Давуу эрхийн хувьцааны давуу талууд

- Энгийн хувьцаа эзэмшигчдээс түрүүлж ногдол ашиг авна.
- Компани ашигтай ажилласан эсэхээс үл хамааран тогтмол хэмжээний ногдол ашиг авна.
- Компани татан буугдах, дампуурах үед энгийн хувьцаа эзэмшигчдээс түрүүлж хөрөнгөө гаргуулна.
- Энгийн хувьцаанд хөрвөх боломжтой байдаг.

Бодит байдал дээр давуу эрхийн хувьцаа эзэмшигчид зээлдүүлэгчийн өр төлбөр төлөгдсөний дараа л хөрөнгөө авах боломжтой учраас ихэнх дампуурлын үед хөрөнгөө гаргуулж авч чаддаггүй. Давуу эрхийн хувьцаа нь энгийн хувьцаатай адилхан эргүүлж төлөх албагүй санхүүжилтийн хэлбэр юм. Мөн ТУЗ-өөс давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

⁵ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes "Personal Finance", 10-th edition, 2012, p 466

"МЭДЛЭГТ ДУСАЛ НЭМЭР"

УИХ-ын 2010 оны 39-р тогтоол, 2012 оны 18-р тогтоол болон Засгийн газрын 2011 оны 3-р сарын 31-ний өдрийн 98-р тогтоол, 2012 оны 4-р сарын 11-ний өдрийн 116-р тогтоолын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 20 хуртэлх хувийг 2012 оны 4-р сарын 11-нээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр болсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 2.7 сая иргэн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаанаас тус бүр 1072 ширхэгийг эзэмших эрхтэй.

Таны эзэмшиж буй "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцаа нь энгийн хувьцаа юм. Харин "Хүний хөгжлийн сангийн тухай" хуульд зааснаар иргэн бүр "Эрдэнэс МГЛ" компанийн нэг ширхэг давуу эрхийн хувьцааг эзэмшинэ. Энэхүү үйл ажиллагааг Монгол Улсын засгийн газрын 2012 оны 06-р сарын 25-ны өдрийн 218 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Уг тогтоолоор хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй иргэн бүр нэг ширхэг давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй. Харин давуу эрхийн хувьцааг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлах нь хуулиар хориотой. Мөн тухайн хүн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмших эрх нь дуусгавар болно.

Хүснэгт 1.3. Энгийн болон давуу эрхийн хувьцааны ялгаа

Энгийн хувьцаа	Давуу эрхийн хувьцаа
<ul style="list-style-type: none"> Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхтэй. 	<ul style="list-style-type: none"> Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхгүй.
<ul style="list-style-type: none"> Ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд авна. 	<ul style="list-style-type: none"> Тогтмол хэмжээний ногдол ашиг олгоно.
<ul style="list-style-type: none"> II ээлжинд ногдол ашгаа авна. 	<ul style="list-style-type: none"> Эхний ээлжинд ногдол ашиг авна.
<ul style="list-style-type: none"> Ногдол ашиг олгоогүй үед компани нөхөн олгох үүрэг хүлээхгүй. 	<ul style="list-style-type: none"> Олгоогүй ногдол ашиг компанийн хувьд өр хэлбэрээр бүртгэгдэх учир заавал нөхөн олгоно.
<ul style="list-style-type: none"> Хөрөнгө хуваарилахад зээлдүүлэгчид, давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн дараа III ээлжинд авна. 	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө хуваарилахад зээлдүүдэгчийн дараа II ээлжинд авна.
<ul style="list-style-type: none"> Компанийн үйл ажиллагааны ашиг алдагдал шууд нөлөөлнө. 	<ul style="list-style-type: none"> Компанийн үйл ажиллагааны ашиг алдагдал бараг нөлөөлдөггүй.
<ul style="list-style-type: none"> Хувьцааны ханшийн өсөлт бууралт хувьцаа эзэмшигчдийн орлогод шууд нөлөөлнө. 	<ul style="list-style-type: none"> Энгийн хувьцааны ханшийн өөрчлөлт давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд нөлөөлөхгүй.
<ul style="list-style-type: none"> Хөрвөх чадвар багатай. 	<ul style="list-style-type: none"> Хөрвөх чадвар ихтэй.
<ul style="list-style-type: none"> Эргүүлэн дуудах боломж багатай. 	<ul style="list-style-type: none"> Эргүүлэн дуудах боломж ихтэй.

Та аливаа хувьцаанд хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө хувьцааны арилжааны мэдээлэлтэй танилцаж, хувьцаатай

холбоотой зохих ёсны судалгааг хийвэл зохино.

Хүснэгт 1.4. Хувьцааны арилжааны дэлгэрэнгүй мэдээ

Симбол	Үнэт цаасны нэр	Ширхэг	Үнийн дүн	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Зах зээлийн үнэлгээ	Авах	Зарах	Арилжаа
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
BAN	Багануур	531	1 217 147.00	2 250.00	2 370.00	2 250.00	2 292.00	48 073 233 120.00	2 150.00	2 400.00	Энгийн

Эх сурвалж. Монголын хөрөнгийн бирж, 2016 оны 10-р сарын 20-ны өдрийн арилжаа

Тайлбар:

1. МХБ-д бүртгэлтэй Багануур ХК-ийн хувьцааны латин үсгээр илэрхийлэгдсэн код;
2. Үнэт цаас гаргаж арилжаалсан компанийн нэр;
3. Тухайн өдөр арилжаалагдсан хувьцааны тоо;
4. Арилжаалагдсан хувьцааны тоог нэгж хувьцааны хаалтын ханшаар үржүүлсэн дүн буюу тухайн өдөр арилжаалагдсан хувьцааны нийт үнийн дүн;
5. Тухайн өдрийн арилжааны нээлтийн ханш. Энэхүү ханш арилжааны өдөр бүр Улаанбаатарын цагаар 09:40-10:00 цагийн хооронд тогтдог;
6. Тухайн өдрийн арилжааны дээд ханш. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн нэгж хувьцааны хамгийн өндөр үнэтэй захиалга 2370 төгрөгөөр хэрэгжсэн;
7. Тухайн өдрийн арилжааны доод ханш. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн нэгж хувьцааны хамгийн бага үнэтэй захиалга 2250 төгрөгөөр хэрэгжсэн;
8. Тухайн өдрийн арилжааны хаалтын ханш. Энэхүү ханш арилжааны өдөр бүр Улаанбаатарын цагаар 13:00-13:05 цагийн хооронд тогтдог;
9. Бүртгэлтэй хувьцааны тоог нэгж хувьцааны хаалтын ханшаар үржүүлсэн дүн буюу 2016 оны 10-р сарын 20-ны өдрийн байдлаарх Багануур ХК-ийн үнэлгээ;
10. Тухайн өдрийн арилжаагаар худалдан авахаар захиалга өгсөн нэгж хувьцааны үнэ;
11. Тухайн өдрийн арилжаагаар худалдахаар захиалга өгсөн нэгж хувьцааны үнэ;
12. Хөрөнгийн бирж дээрх арилжаа энгийн болон багцын гэсэн 2 төрөлтэй. Хувьцааны арилжаа ердийн горимын дагуу явагдсаныг илэрхийлж буй энгийн арилжаа.

Үнэт цаасанд хичнээн хэмжээний хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахдаа дараах төрлийн мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглаж болно. Үүнд:

Хүснэгт 1.5. Үнэт цаасны талаарх мэдээллийн эх сурвалжууд⁶

№	Мэдээллийн эх сурвалж	Тайлбар
1.	Интернэт	Та интернэтээс хадгаламжийн сертификатын хүүний хувь, хувьцаа, бондын өнөөгийн үнэ, компанийн үнэт цаасыг худалдан авах, эзэмших, зарах талаарх брокерүүдийн зөвлөмж гэх мэт өдөр тутмын мэдээллийг авахаас гадна интернэтийн сүлжээ ашиглан хувьцааны цахим худалдаа хийх боломжтой болсон. Түүнчлэн, төр захиргааны байгууллага, банк санхүүгийн байгууллага, томоохон компаниудын цахим хуудсаар аялж, хөрөнгө оруулалтын талаарх үнэ цэнэтэй мэдээллийг авах боломжтой.
2.	Сонин, мэдээллийн программ	Улс орны эдийн засаг, улс төр, нийгмийн байдлаас гадна салбарын төлөв байдал зэрэг нарийн төрөлжсөн бусад мэдээллийг авах боломжтой. Түүнчлэн хувьцаа, бонд, хамтын сан, бусад хөрөнгө оруулалтуудын үнийн санал, томоохон хэлцлүүдийн мэдээллийг авч болох юм. Тухайлбал, Bloomberg, “Санхүүгийн лавлах мэдээ” сонин г.м.
3.	Бизнесийн тогтмол хэвлэл	Ихэнхи бизнесийн тогтмол хэвлэлүүд долоо хоног, 2 долоо хоног, сар тутамд хэвлэгдэж гарч байдаг. Жишээ нь, Бизнесийн мэдээ, хөрөнгийн зах зээл, гэх зэрэг сэтгүүлүүд орж болно.
4.	Засгийн газрын хэвлэл	Монгол банкны тайлан, Санхүүгийн зохицуулах хорооны тайлан зэрэг нь хөрөнгө оруулагчдад нэн шаардлагатай мэдээллийг агуулдаг.

6 Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes. (2012), “Personal Finance”, 10th ed. P447.

№	Мэдээллийн эх сурвалж	Тайлбар
5. Компанийн тайлан		Төр засгийн болон хяналт шалгалтын, зохицуулах байгууллагуудаас биржид бүртгэлтэй компаниудыг ашиг орлого, хөрөнгө, өр төлбөр, бүтээгдэхүүн үйлчилгээ, удирдлагын багийн бүрэлдэхүүн гэх мэт компанийн үйл ажиллагаатай холбоотой, хувьцааны үнэд нөлөөлж болох мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангахыг үүрэг болгож байдаг. Жилийн тайлан нь хөрөнгө оруулагчдыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангахаас гадна компанийн цахим хуудсанд татаж авч болохоор тавигдсан байдаг.
6. Хөрөнгө оруулагчдад үзүүлэх үйлчилгээ ба сонин		Хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах үйлчилгээ янз бүрийн төлбөртэй байдаг. Зарим үйлчилгээ төлбөргүй байдаг. Тухайлбал, www.mse.mn , www.frc.mn , www.schcd.mn , www.masd.mn гэх мэт цахим хуудсуудад хөрөнгө оруулалттай холбоотой үнэ ханшийн болон эрх зүйн мэдээллүүд үнэгүй байдаг.

ТАНД СОНИРХУУЛАХАД

Үнэт цаас, хувьцааны талаар ойлголтгүй байсан нь олон хүний хувьд цэнхэр, ягаан тасалбараа будаа, гурил, эсгий гутлаар солиход хүргэжээ. Дахиад тэдний алдааг давтах хэрэггүй. 1992 онд Монгол Улсын 1.1 сая иргэнд 475 улсын үйлдвэрийн газрыг цэнхэр, ягаан тасалбараар эн тэнцүүхэн хувьчилж өгсөн. Гэтэл энэ хөрөнгө Монгол Улсын нийт хүн амын 1 хувь хүрэхгүй хүний гарт төвлөрч байна гэвэл та итгэх үү? Үнэндээ бол тийм.

Хувьцааны ашиг тусыг мэддэг хүмүүс хувьцаа цуглуулж, харин мэддэггүй нь сольж, зарж үгүй хийсэн. Ерээд онд ийм л юм болсон. Ихэнх хүмүүс үнэт цаасны зах зээл гэж юу болох, хувьцаа ямар ашиг тустай болох талаар ойлголтгүйгээсээ болж хөрөнгө оруулалтын эрхийн бичиг болох цэнхэр, ягаан тасалбараа ашиглаж чадаагүй. Иймээс үнэт цаасны зах зээл, хувьцааны талаар ойлголттой болох хэрэгтэй.

1.3. БОНДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Бондын хөрөнгө оруулалт нь сүүлийн 100 гаруй жилийн турш дэлхийн голлох хөрөнгө оруулалт байсаар иржээ.

Бондыг хэн гаргах вэ?

Бондыг Засгийн газар болон компаниуд гаргаж худалддаг. Аль ч улсын засгийн газар санхүүжилтийн эх үүсвэр олж авах зорилгоор бонд гаргаж болно. Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр эргүүлэн төлөхөөр Засгийн газраас бичгээр гаргасан баталгааг засгийн газрын бонд гэнэ. Өрийн бичиг гэдэг нь тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн өрийн үнэт цаас юм.

Өөрийн эзэмшлийг бусадтай хуваалцах сонирхолгүй, хүү төлөх чадвартай компаниуд бонд гаргадаг. Компанийн бонд нь тодорхой хүүтэй эргүүлэн төлөхийг амласан өрийн бичиг юм. Компанийн бондыг гаргасан хугацаанаас нь хамааруулж, богино (5 хүртэл жил), дунд (5-15 жил), урт хугацааны (15-аас дээш) гэж ангилж болно.

Компанийн бонд гаргахын давуу тал:

- Хувьцаа эзэмшигчдийн байр суурийг өөрчлөхгүйгээр хөрөнгөө нэмэгдүүлэх боломж олгодог.
- Банкны хүүтэй харьцуулахад харьцангуй бага хүүтэй зээл авах боломжтой.
- Банкны зээлээс илүү урт хугацаатай хөрөнгийн эх үүсвэр болдог.
- Бонд гаргагчийн хувьд өртөг хямд байдаг.

Хөрөнгө оруулагч нар дараах нөхцөл, шалтгааны улмаас бондод хөрөнгө оруулалт хийдэг. Үүнд:

- Хүүний орлого хүртдэг.
- Үнэ цэнэ нь боломжийн хэмжээнд өсдөг.
- Хамгийн их боломжит ашиг олдог.
- Хугацаандаа төлөгддөг.
- Эрсдэлийг тараан байршуулах боломжтой.

Хувьцаа нь эзэмшигчдээ өмчлөх эрхийг олгодог бол бонд нь эзэмшигчээ зээлдүүлэгч гэдгийг баталгаажуулдаг. Бонд нь хувьцаанаас ялгагдах өөрийн гэсэн онцлогтой.

Хүснэгт 1.6. Хувьцаа бондын ялгаа

Хувьцаа	Бонд
Компани гаргадаг.	Засгийн газар, орон нутгийн байгууллага, компани гаргадаг.
Эргүүлж төлөх нөхцөлгүй хөрөнгө оруулалт.	Тодорхой хугацааны дараа эргүүлж төлнө.
Эзэмшигч нь хувь эзэмшилдээ оногдох ногдол ашиг авна.	Эзэмшигч нь үндсэн дүнгээс тооцож хүү авна.
Хувьцааны ногдол ашиг компанийн ашигт ажиллагаанаас хамаарах тул тогтмол биш байж болно.	Компанийн ашиг алдагдлаас үл хамааран анх тогтоосон хүүг тогтмол дүнгээр авна.
Хөрвөх чадвар сайтай. Хоёрдогч зах зээл дээр арилжаалагддаг.	Хөрвөх чадвар хувьцаанаас сул. Гэхдээ хүссэн үедээ хоёрдогч зах зээл дээр арилжиж болно.
Компани оршин тогтнох бүх л хугацаанд хүчин төгөлдөр.	Зээлийн хугацаанд хүчин төгөлдөр.
Компани дампуурвал хувьцаа эзэмшигчид өөрт ноогдох хөрөнгийг компанийн бүх өр төлбөр, зээлийг барагдуулж дууссаны дараа авна.	Компани дампуурвал зээл олгогчид өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт хамгийн түрүүнд авна.
Үнийн өөрчлөлт их.	Үнийн өөрчлөлт бага.
Ашиг өндөр → Эрсдэл их.	Ашиг бага → Эрсдэл бага.

Бонд нь гаргах болон төлбөр хийх нөхцөл, хөрвөх боломж, эрсдэлийн түвшин гэх зэрэг янз бүрийн онцлог шинжээсээ хамаарч олон төрөл байна. Тухайлбал, хөрвөх бонд, индексжүүлсэн бонд, хөвөгч хүүтэй бонд, хүүгүй бонд, орлогын бонд, евро бонд гэх мэтээр ангилж болно.

Засгийн газрын үнэт цаасны төрлүүд

Засгийн газрын бондыг УИХ-аас зөвшөөрсний үндсэн дээр Сангийн яам гаргадаг. Засгийн газрын бондын арилжаа нь 2015 оны 2 сарын 18-ны өдөр батлагдсан “Өрийн удирдлагын тухай” хуулиар зохицуулагддаг. Засгийн газрын бондыг гаргахад дараах

шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Тухайн жилийн төсвийн хуульд тусгасан байх;
2. Гаргах үнэт цаасны үнийн дүн нь энэ хуульд заасны дагуу тухайн төсвийн жилийн зээллэгийн дээд хэмжээнд нийцсэн байх;
3. Стратегийн баримт бичигт нийцсэн байх шаардлагатай.

Засгийн газар нь төсвийн түр зуурын дутагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дараах төрлийн үнэт цаасыг гарган гадаад, дотоод, мөнгөний болон хөрөнгийн зах дээр арилжаалдаг. Үүнд:

1. Засгийн газрын вексель. Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичиг. Энэхүү вексельд төлбөрийн хугацаа болтол хүү төлдөггүй.

2. Засгийн газрын дунд хугацааны өрийн бичиг. Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш, 10 жилээс доош хугацаатай өрийн бичиг. Энэ нь засгийн газрын вексельтэй харьцуулахад өндөр хүү төлдөг. Хүүг 6 сар тутамд төлдөг.

3. Засгийн газрын бонд. Засгийн газраас гаргасан 10-30 жилийн хугацаатай өрийн бичиг. Сангийн вексель болон ноттой харьцуулахад өндөр хүүтэй. Хүүг 6 сар тутамд төлдөг. Үнэ нь хугацаанаас хамаардаг.

4. Орон нутгийн бонд. Орон нутгийн засаг захиргаанаас гаргасан өрийн бичиг. Энэ төрлийн бондыг улсын болон орон нутгийн чанартай үйл ажиллагаа, сургууль эмнэлэг, зам гүүр г.м төслүүдийг санхүүжүүлэхээр гаргадаг. Онцлог нь: Энэ төрлийн бондын хүү нь орон нутгийн татвараас чөлөөлөгддөг.

ТАНЫ СОНОРТ

Монголын анхны өрийн бичиг “Бага болзоот”-ыг 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй, жилийн 6 хувийн хүүтэй, олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны арван сарын хорин хүртэл хугацаагаар гаргаж байжээ. 1950 онд Сангийн яамнаас урьд гаргагдсан бүх зээллэгээ нэгтгэн 20 жилийн хугацаатай нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800000 ширхэг өрийн бичгийг гаргасан байдаг. Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд Засгийн газраас хэд хэдэн удаа өрийн үнэт цаас гаргаж дотоод болон олон улсын зах зээл дээр арилжаалсан байна. Үүнд Хөгжлийн банкны Евро бонд, Засгийн газрын Чингис бонд, Самурай бонд гэх мэт.

1.4. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ

www.sankhuuginbolovsrol.mn

Ерөнхийдөө инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог учир хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулдаг. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтыг шууд ба шууд бус гэж ангилдаг.

Шууд хөрөнгө оруулалт нь орон сууц, газар, зуслан, ашиг олох зорилготой хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалт. Орон байр бол нэгдүгээрт, амьдрах зориулалттай, хоёрдугаарт, инфляцийн эсрэг хамгаалалт хийх боломжтой, орлого олох зорилготой байдаг.

Харин зуслангийн байр бол эрүүл агаарт гарч, тав тухтай амрахыг хүссэн хүмүүст тохиромжтой хөрөнгө оруулалт. Ер нь хоёр дахь орон байраа худалдан авах боломжтой болсон хүмүүс нэг бол зуслан, нөгөө бол түрээслүүлэх орон сууц гэсэн сонголттой тулгарч байдаг байна.

Арилжааны ашиг олох зорилготой хөрөнгө оруулалтад түрээсэлж ашиг олох зорилготой газар, барилга,

байгууламж хамаарна. Үүнд: орон сууц, зочид буудал, оффис, дэлгүүр болон бусад бүх төрлийн арилжааны зориулалттай байгууламж орно.

Газрын хөрөнгө оруулалтын тухайд үргэлж мөнгөний урсгал бий болгохгүй гэдгийг санах хэрэгтэй. Ихэнх хөрөнгө оруулагчид газрыг хувааж, ашиглах зорилгоор худалдан авдаг. Харин арилжааны зориулалттай худалдан авах нь ихээхэн эрсдэл дагуулдаг. Тухайлбал, цэвэр, бохир ус болон бусад үйлчилгээ явуулах боломжийг бодолцох хэрэгтэй. Шууд бус хөрөнгө оруулалт нь хязгаарлагдмал нөхөрлөл, үл хөдлөх хөрөнгийн синдикат, үл хөдлөх хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан, моргейж, моргейжийн санд оруулах хөрөнгө оруулалт болно. Ерөнхийдөө, илүү чадвартай хөрөнгө оруулагчид л моргейж болон бусад өрийн гэрээг худалдан авдаг. Эдгээр хөрөнгө оруулалт өндөр өгөөжтэйн хэрээр эрсдэл ихтэй.

Хүснэгт 1.7. Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулахын давуу болон сул тал

Давуу тал	Сул тал
Инфляцийн эсрэг хамгаалалт хийх боломжтой.	Хөрвөх чадвар муутай байдаг.
Хязгаарлагдмал санхүүгийн хариуцлага хүлээдэг.	Хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй.
Удирдлагын хувьд сэтгэл зовох асуудал бага байдаг.	Эрсдэлийг тараан байршуулах боломж дутагдалтай.
Санхүүгийн хөшүүрэг болно.	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт хязгаарлагдмал.
Валютын ханшийн эрсдлээс хамгаалалт хийх боломжтой.	Урт хугацаанд элэгдэлд орох нь элбэг.